

**Монгол Улсын хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн
хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан,
2022 оны жилийн эцсийн байдлаар, Эрүүл мэндийн яам**

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
1. “КОВИД-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого							
1	1.1. “КОВИД-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1.1.1. Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлох, вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлох Шалгуур үзүүлэлт: Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлох, вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлох		Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлсон байна. Вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлсон байна.		Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/620 дугаар тушаалаар Коронавируст халдвар (COVID-19)-ын судалгааг зохион байгуулах удирдах ажлын хэсэг, судалгааны тэргүүлэх 10 чиглэлийг батлуулж, судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2022 оны 11 дүгээр сард судалгааны ажлын үр дүнг хүлээн авч, хэвлүүлсэн. Монгол Улсад тархаж байгаа коронавируст халдварын геномын дараалал, бүтцийг тодорхойлсон. Үүнд: 1. Монгол Улсад КОВИД-19 цар тахал үүсгэсэн SARS-CoV-2 вирусийн геномын шинжийг судалсан судалгааны дүгнэлтэд манай улсад SARS-CoV-2 вирусийн Альфа, Дельта, Омикрон гэх 3 хувилбар, 25 PANGO линийг тодорхойлогдсон. Цар тахлын эхний давалгаа үүссэн нь B.1.1, B.1.1.46 PANGO линийжаар үүсгэгдсэн бол гурван давалгаа Альфа, Дельта, Омикрон хувилбаруудаар нөхцөлджээ. Манайд илэрсэн омгууд лавлагаа hCoV-19/Wuhan/Hu-1/2019 омгоос 4-48 аминхүчлээр ялгаатай байсан бөгөөд удмын нэг төрлийн дэд клэйдэд хамааралтай омгууд ORF1a болон S уургийн аминхүчлийн өвөрмөц өөрчлөлтүүдээс шалтгаалан шинэ бүлгүүдэд хуваагдаж байв. Монгол Улсад SARS-CoV-2 вирусийн гадаргуугийн S уургийн аминхүчлийн V143F, S640F өөрчлөлттэй шинэ хувилбар өвчлөл үүсгэсэн ба вирусийн генийн хувьсал үргэлжлэх хандлагатай байна гэжээ. 2. Монгол Улсад КОВИД-19 цар тахал үүсгэсэн Дельта хувилбарын SARS-CoV-2 вирусийн геномыг судалсан судалгааны дүгнэлтэд Монгол Улсад SARS-CoV-2 вирусийн Дельтагийн 10 хувилбар зөөвөрлөгдөн	100.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
						орж ирсэн ба 4 хувилбар нь дотоодын халдвар үүсгэсэн. Орчилд орсон Дельта хувилбарт геномын шинэ өөрчлөлт гараагүй байна гэжээ. КОВИД-19 вакцинжуулалт болон халдварын дараах SARS-CoV-2 вирусийг саармагжуулах идэвхийн судалгаа, КОВИД-19 эсрэг вакцины гурав дахь сэргээх тунгийн дараах дархлааны хариу урвал болон дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн судалгааны үр дүн гарсан байна.	
2		1.1.2. Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх Шалгуур үзүүлэлт: Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх		Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийгдэж, нөөцийг шинэчилж сэлгэсэн байна.		Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. - КОВИД-19, сармагчны цэцэг зэрэг Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-ийн дагуу мэдээлж, “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал” хэмээн зарласан халдварт өвчний эрсдэлийн үнэлгээг УОК, ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ болон бусад холбогдох байгууллагууд хамтран зохион байгуулж хэвшсэн. 2022 онд КОВИД-19-ын эрсдэлийн үнэлгээг 1, сармагчны цэцэг өвчний эрсдэлийн үнэлгээг 3 удаа тус тус хийж, эрсдэлийг бууруулах зөвлөмж гарган, хэрэгжүүлж байна. Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцийг гадаад эх үүсвэрээс бүрдүүлэхэд анхаарч, АХБ, Япон Улсын Засгийн газар, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан, Олон талт хамтын ажиллагааны КОВАКС механизмын хүрээнд нийт 41.4 тэрбум төгрөгийн эм, хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж хүлээн авч, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.	100.0
3		1.1.3. Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг тус тус байгуулах		Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг байгуулсан байна.		2024 онд Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Төв аймагт 33 орон тоо бүхий “Зоонозын өвчин судлалын төв” болон хилийн 12 боомтод 8 орон тоо бүхий “Тандалтын нэгж”-ийг тус тус байгуулж, Ховд, Увс, Өмнөговь, Дундговь, Архангай аймгийн “Зоонозын өвчин судлалын төв”-д барилга, байгууламж барихад шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын	30.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		Шалгуур үзүүлэлт: Зоонозын өвчин судлалын төвийг 2 аймагт, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг тус тус байгуулах				<p>зардлыг шийдвэрлэх” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1а/5053 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Харин ЗГХЭГ-аас 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн ХЭГ/2957 тоот албан бичгээр тандалтын нэгжийг хууль тогтоомжид нийцүүлэн байгуулах асуудлыг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргатай зөвшилцөж шийдвэрлэх зүйтэй, мөн Зоонозын өвчин судлалын төвийг тухайн аймгийн Эрүүл мэндийн газрын санал, дүгнэлт, хэрэгцээ, шаардлагад үндэслэн шийдвэрлэх нь зүйтэй гэж тогтоолын төслийг буцаасан байна.</p> <p>Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймагт ЗӨСТ байгуулах талаар үндэслэл, танилцуулга, шаардагдах төсвийг 2023 оны төсвийн төсөлд тусгасан ч 2023 онд шинээр барилга байгууламж барихгүй шийдвэртэй холбоотой хойшилсон.</p> <p>АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Дорнод аймгийн Хавирга, Увс аймгийн Боршоо, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хилийн боомтод тандалтын нэгж байгуулах үндэслэл, танилцуулга, санхүүжилтийн тооцоог хийж хүргүүлсэн бөгөөд төслийн Удирдах хорооны хурлаар дэмжигдэж, АХБ-ны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд 2023 онд нийлүүлэгдэхээр болсон.</p>	
4		1.1.4. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийн агуулах шинэчлэн барих барилгын ажлыг		Агуулахын барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна.	1.000.00	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ)-ийн эзэмшлийн газрын баруун хойд хэсэгт 0.58 га. талбай бүхий Улаанбаатар хотын төв цэгээс 10 км зайд, Сонгинохайрхан, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сонсголгонгийн замын дагуу газарт шинэчлэн барьж, ашиглалтад оруулсан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн А/331 дүгээр тушаалаар агуулахын тоног	100.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		<p>эхлүүлж, 30 хувьд хүргэх</p> <p>Шалгуур үзүүлэлт: Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийн агуулах шинэчлэн барих барилгын ажлыг эхлүүлж, 30 хувьд хүргэх</p>				<p>төхөөрөмжийг орлогод авч хуваарилан үндсэн хөрөнгийн бүртгэлд авсан байна.</p> <p>АХБ-ны “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” төслийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд ЗӨСҮТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахын барилга барихад 6.7 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 1.6 тэрбум төгрөг, нийт 8.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн.</p>	
5		<p>1.1.5. 5 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжөөр хангаж, ашиглалтад оруулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: 5 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжөөр хангаж, ашиглалтад оруулах</p>		<p>Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжөөр бүрэн хангаж, шинээр 5 аймгийн нэгдсэн эмнэлгийг полимеразын гинжин урвалын шинжилгээ хийх төхөөрөмжтэй болгож, лабораторийн чадавхыг нэмэгдүүлсэн байна.</p>		<p>Булган, Төв, Дундговь аймагт молекул биологийн лабораторийг шинээр байгуулж ашиглалтад оруулснаар нийт 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт молекул биологийн лаборатори байгуулагдаад байна. Молекул биологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 202 лабораторид 2022 оны 04 дүгээр сард Олон улсын гадаад чанарын хяналтыг явуулсан. Түүнчлэн 2022 онд Люксембургийн Их Гүнт Улсын санхүүжилтээр “Цар тахлын үед эхийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах” төслийг хэрэгжүүлж, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Өргөө, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт молекул биологийн шинжилгээ хийх иж бүрэн лабораторийг байгуулсан. Төслийн хүрээнд 109,726.76 ам.долларын үнэ бүхий 22 нэр төрлийн молекул биологийн оношилгооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслүүдийг лабораторийн стандарт тавилгын хамт хүлээлгэн өгсөн. Лаборатори нь КОВИД-ын халдвараас гадна нөхөн үржихүйн замын халдварууд, умайн хүзүүний хавдрын үүсгэгчийг илрүүлэх урвалж бодис, технологийн хамт нийлүүлэгдэж байгаагаараа онцлог. Нийлүүлэгч компани сургалтыг тоног</p>	100.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
						төхөөрөмж болгоноор хийж, эмнэл зүйн сургалтыг ЭМЯ, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан.	
2. Хүний хөгжлийн бодлого							
6	2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	2.1.1. Зүрх судасны төвийн барилгын ажлыг эхлүүлэх Шалгуур үзүүлэлт: Зүрх судасны төвийн барилгын ажлыг эхлүүлэх		Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.		Зүрх судасны төвийн зураг төсвийг Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “Зүрх судасны төв байгуулах” төслийн 1.5 сая еврогийн буцалтгүй тусламжаар Испани Улсын “Идом” ХХК гүйцэтгэж, барилга угсралтын ажлын дүн 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажсан. Барилгын төсвийн эх үүсвэрийг 2022 оны улсын төсөвт тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч батлагдаагүй, төсөвгүй гэх шалтгаанаар барилгын гүйцэтгэл гацсан байна. Төвийн барилгыг Улсын гуравдугаар төв эмнэлгийн хашаанд барихаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. Зүрх судасны төвийн барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй.	0
7		2.1.2. Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлыг эхлүүлэх; Төв ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн тооцооллыг хийх Шалгуур үзүүлэлт: Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлыг эхлүүлэх; Төв		Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна. Төв ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн /хүний нөөц, тоног төхөөрөмж, бусад/ тооцооллыг хийсэн байна.		Эрхтэн шилжүүлэн суулгах төв нь Улаанбаатар хот, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хашаанд 60.2x30 м хэмжээтэй цоколийн 2 давхартай, 8 давхар барилгатай, шаардлагатай дэвшилтэт тоног төхөөрөмж, мэргэжилтнүүдээр бүрэн хангагдсан байхаар төлөвлөгдсөн. Тус төсөл арга хэмжээний ТЭЗҮ боловсруулагдсан бөгөөд 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг шаардлагатай. Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй.	0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн тооцооллыг хийх					
8		2.1.3. Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх Шалгуур үзүүлэлт: Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх		Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна.		Сүрьеэгийн эмнэлгийн барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажил Засгийн газрын тогтоолоор Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж, “Хар чонот” ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжийн дагуу гэрээний төсөл боловсруулах үед “Хар чонот” ХХК нь Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх тухай” 213 дугаар тушаалаар батлагдсан жагсаалтад бүртгэгдсэн тул гэрээ байгуулах боломжгүй болж, тендерийг 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр дахин зарласан. Дахин зарласан тендерийг “Захиргааны актын биелэлтийг түтгэлзүүлэх тухай” Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн шүүгчийн 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 128/Ш32022/7229 захирамжаар захиргааны хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл түр зогсоогоод байна. Барилгын ажлын төсөвт өртөг 18.5 тэрбум төгрөг бөгөөд 2022 оны улсын төсөвт 2 тэрбум төгрөгөөр суусан боловч ажил эхлээгүй. Сүрьеэгийн эмнэлгийн барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй. Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулалт 100%. Барилгын ажил эхлээгүй.	0
9		2.1.4. Геронтологийн төвийн барилгын ажлын гүйцэтгэлийг 70 хувьд хүргэх		Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.		Монгол Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдээс эрүүл мэндийн салбарт Геронтологийн төвийн барилга царцсан, барилга угсралтын ажил хийгдээгүй байна.	50.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		Шалгуур үзүүлэлт: Геронтологийн төвийн барилгын ажлын гүйцэтгэлийг 70 хувьд хүргэх				Барилга угсралтын ажлын зураг төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдсэн. Төсөвт өртгийн нэмэгдлийг Сангийн яаманд 2020-2023 онуудын төсвийн тухай хуульд тусгуулахаар өргөн барьсан боловч төсөвт өртөг нэмэгдэж батлагдаагүй. Харин Сэргээн засах төвийн барилга, 36 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/-ын ажлын явц 46 хувьтай байгаа ба 2023 оны төсвийн хуулиар 4,616.5 сая төгрөг төсөвт өртөг бүхий 828.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй батлагдсан. Иймд Сэргээн засах төвийн барилгыг 2023 онд бүрэн ашиглалтад оруулж Геронтологийн үндэсний төв болгон ашиглана.	
10		2.1.5. Орон нутагт яаралтай тусламжийн 10 цэг байгуулах Шалгуур үзүүлэлт: Орон нутагт яаралтай тусламжийн 10 цэг байгуулах		Орон нутагт шаардлагатай 10 цэгт яаралтай тусламжийн цэг байгуулсан байна.	51.3 сая төгрөг (ДЭМБ)	Осол, гэмтэл ихээр гардаг Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Хөвсгөл аймгийн Хатгал, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Булган аймгийн Хутаг өндөр, Архангай аймгийн Тариат, Ховд аймгийн Булган, Завхан аймгийн Их-Уул, Орхон аймгийн Баян-Өндөр, Өвөрхангай аймгийн Хархорин, Сэлэнгэ аймгийн Мандал сум зэрэг 10 цэгт яаралтай тусламжийн жишиг цэгийг байгуулахад шаардлагатай тоног, төхөөрөмжийн худалдан авалтыг ДЭМБ-ын санхүүжилтээр хийж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/502 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад тоног төхөөрөмжийг хуваарилсан (255.9 сая төгрөг). Яаралтай тусламжийн эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхийг сайжруулах зорилгоор 2022 оны 12 дугаар сарын 17-19-ний өдөр “Сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж, орон нутгийн 40 гаруй эмч, сувилагч хамрагдсан (51.3 сая төгрөг).	90.0
11		2.1.6. Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн барилгын зураг,		Зураг, төсөв хийгдэж, барилгын ажил эхэлсэн байна.		Барилга, хот байгуулалтын сайдын багцад 268,9 сая төгрөгийн төсөвт өртөг тусгагдсан бөгөөд зураг төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, “Татах хүч” ХХК-тай гэрээ байгуулан зураг төсөв хийгдэж	30.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		төсвийг хийж, барилгын ажлыг эхлүүлэх Шалгуур үзүүлэлт: Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн барилгын зураг, төсвийг хийж, барилгын ажлыг эхлүүлэх				байна. Уг эмнэлгийн барилгыг барихаар олгогдсон 7,000 м ² газарт эмнэлгийн барилга багтахгүй байгаа тул газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж, мөн зураг төсвийн ажил хүлээгдэж байна. Баянзүрх дүүрэгт барих 300 ортой эмнэлгийн барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй.	
12		2.1.7. Эрүүл мэндийн салбарын 26 байгууллагад мэдээллийн сүлжээний дэд бүтэц бий болгох Шалгуур үзүүлэлт: Эрүүл мэндийн салбарын 26 байгууллагад мэдээллийн сүлжээний дэд бүтэц бий болгох		26 байгууллага-сүлжээний дэд бүтэцтэй болсон байна.		Эрүүл мэндийн салбарын "VPN" хамгаалагдсан мэдээллийн сүлжээний дэд бүтцийг Мобиком, Юнител зэрэг байгууллагуудтай хамтран Эрүүл мэндийн хөгжлийн төвд байгуулж, нийт 48 эрүүл мэндийн байгууллагыг холбосон сүлжээний дэд бүтэц бий болсон. Үүнд: 16 аймгийн нэгдсэн эмнэлэг, 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 4 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 5 Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, 6 хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, ЭМЯ-ны харьяа лавлагаа шатлалын 8 эмнэлэг болно.	100.0
13		2.1.8. Эрүүл мэндийн байгууллагын 50 хувьд мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх Шалгуур үзүүлэлт: Эрүүл мэндийн байгууллагын 50		Эрүүл мэндийн байгууллагын 50 хувьд мэдээлэл солилцооны платформ нэвтэрсэн байна.		Дэлхийн банкны санхүүжилтээр "Цахим эрүүл мэнд" төслийн туслан гүйцэтгэгч "Аксис системс" ХХК-тай хамтран нийт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээнд ашиглаж байгаа програм хангамжид (хувийн эрүүл мэндийн байгууллагуудад ашигладаг Медсофт И-клиник, Вингс, Гиганет, Карте зэрэг систем) хадгалагдаж буй иргэний эрүүл мэндийн мэдээллийг нэгтгэсэн. Мөн Үндэсний дата төвд сервер тоног төхөөрөмжүүд байршуулан ЭМДЕГ-тай гэрээ бүхий лавлагаа шатлалын болон анхан шатны эмнэлэг, 50 гаруй хувийн эмнэлэг зэрэг эрүүл мэндийн	100.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		хувьд мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх				байгууллагуудыг мэдээлэл солилцооны платформ системд холбож, нийт эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны платформыг нэвтрүүлсэн.	
14		2.1.9. Дүрс архивлан хадгалах, дамжуулах /PACS/ нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх Шалгуур үзүүлэлт: Дүрс архивлан хадгалах, дамжуулах /PACS/ нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх		Эрүүл мэндийн байгууллагуудад PACS систем бүрэн ашиглагдаж эхэлсэн байна.		Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд 7 эрүүл мэндийн байгууллага (Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл, согог судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хөвсгөл, Увс, Булган аймгийн нэгдсэн эмнэлэг)-д оношилгоо, эмчилгээний дүрс архивлан хадгалах, солилцох “PACS” системийг нэвтрүүлэн ашиглаж байна.	100.0
15		2.1.10. Лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 15 аймгийн А зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд телемедицин нэвтрүүлэх Шалгуур үзүүлэлт: Лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 15 аймгийн А зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд телемедицин нэвтрүүлэх		Лавлагаа шатлалын 4-эрүүл мэндийн байгууллага, 15 аймгийн А зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд телемедицин нэвтэрсэн байна.		МН кардио програм хангамжийг ЭМЯ-ны Техникийн хороо болон Мэдээллийн технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж ашиглах шийдвэр гарч, алсын зайн анагаах ухааны суурь системийг лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 9 аймгийн А зэрэглэлийн 18 сумын эрүүл мэндийн төвд шинээр нэвтрүүлсэн. Уг системийг анхан болон лавлагаа шатлалын 264 эрүүл мэндийн байгууллагын 574 хэрэглэгч ашиглан телемедицинээр тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/129 дугаар тушаалаар “Телемедициний үндэсний сүлжээний ажиллах журам”-ыг шинэчлэн батлуулан хэрэгжүүлж байна.	100.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
16		<p>2.1.11. Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх</p> <p>Шалгуур үзүүлэлт: Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх</p>		<p>Эрүүл мэндийн байгууллагын 20 хувьд цахим бүртгэлийн тогтолцоо нэвтэрсэн байна.</p>		<p>Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ бүхий 828 гаруй эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээний цахим тогтолцоо нэвтрүүлсэн. Олон улсын "Эрүүл мэндийн үндэсний тооцооны систем-2011" аргачлалын дагуу үндсэн 9 ангиллаар тооцооллыг гаргаж байна. Энэхүү ангиллаар санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтарсан 7 удаагийн уулзалт хурлыг зохион байгуулсан. Тайлангууд нэгтгэгдэж байна.</p>	90.0
17		<p>2.1.12. Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх</p> <p>Шалгуур үзүүлэлт: Эрүүл мэндийн даатгалд</p>		<p>Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалт 95 хувьд хүрсэн байна.</p>		<p>2022 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар эрүүл мэндийн даатгалд нийт 3,160,834 даатгуулагч хамрагдаж, хамрагдалтын хувь 93.0 байна.</p>	90.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх					
18		2.1.13. Олон улсын эмнэлзүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлэх Шалгуур үзүүлэлт: Олон улсын эмнэлзүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлэх		Олон улсын 2 эмнэлзүйн удирдамжийг эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлсэн байна.		Эрүүл мэндийн салбарт UpToDate олон улсын цахим платформыг нэвтрүүлэн платформыг хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтын багц цагийн 1/3-ийг платформуос бүрдүүлэх боломжтой болсон. Мөн платформыг сурталчлах, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан платформын талаарх сургалтыг тогтмол хийж байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 45,112 хэрэглэгч платформыг ашиглаж байгаа нь сар бүр платформ хэрэглэгчдийн тоо тогтмол нэмэгдэж байгаа үзүүлэлттэй байна (2022 оны 08 дугаар сар 25,254, 09 дүгээр сар 36,209, 10 дугаар сар 44,009 хэрэглэгч). Платформын талаар 2022 онд зохион байгуулсан 2 удаагийн сургалтад 1,132 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан (төр, хувийн хэвшил, нийслэл, орон нутаг) байна.	100.0
19		2.1.14. Эм ханган нийлүүлэх байгууллагуудад эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтын нэгдсэн программ хангамж нэвтрүүлэх Шалгуур үзүүлэлт: Эм ханган нийлүүлэх байгууллагуудад эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтын		Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтад эм ханган нийлүүлэх байгууллага 100 хувь хамрагдсан байна.		Лайсмед программд нэвтэрч эмийн аюулгүй байдлын тайлан илгээх боломжтой 384 эм ханган нийлүүлэх, үйлдвэрлэх байгууллагыг цахимжуулах ажил бүрэн хийгдсэн байна. Тус хугацаанд 89 эмийн аюулгүй байдлын тайланг Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэсэн. Тус тайлангуудад эмийн аюулгүй байдал зөрчигдөөгүй, өөрчлөлт ороогүй байна.	100.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		нэгдсэн программ хангамж нэвтрүүлэх					
20		2.1.15. Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг холбож, мэдээллийн санг бүрдүүлэх Шалгуур үзүүлэлт: Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг холбож, мэдээллийн санг бүрдүүлэх		21 аймгийн нэгдсэн эмнэлэг сүлжээнд холбогдож, нянгийн тэсвэржилтийн талаарх мэдээллээ өгч хэвшсэн байна.	2	Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд нэгдэх бэлтгэл ажлыг хангаж, нянгийн тэсвэржилтийн WHO.NET программ дээр ажиллаж сургах сургалтад 21 аймгийн эмч, мэргэжилтнүүдийг хамруулах хөтөлбөр, төлөвлөгөөг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Няг судлалын лабораторитой хамтран боловсруулж байна. ДЭМБ-ын Номхон далайн Баруун бүсийн Нянгийн тэсвэржилтийн тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн манай улсад 2022 оны 10 дугаар сарын 10-14 ний хооронд ажиллаж 2022 оны 10 сарын 13-ны өдөр “Нянгийн тэсвэржилтийн тандалт, тэсвэржсэн нянгийн мэдээллийг боловсруулах нь” сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 40 хүн хамрагдсанаас цахимаар 21 аймгийн лабораторийн 25 хүн оролцжээ. WHONET-ийн тухай ойлголт, хэрэглээ, дүгнэлт гаргах аргачлал, шинэчлэлийн талаар олон улсын зөвлөх дэлгэрэнгүй мэдээлэл өгч, манай улсад WHONET програмыг хэрхэн ашиглаж байгаа болон Монгол Улс тэсвэржсэн нянгийн мэдээллийг ДЭМБ-ын “GLASS” системд хүргүүлдэг болох талаар мэдээллийг түгээсэн байна.	30.0
21		2.1.16. Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийг эх орондоо үйлдвэрлэдэг болоход түүхий эдийг татвараас чөлөөлөх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх Шалгуур үзүүлэлт:		Хууль, эрх зүйн орчин бүрдэж, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн дотоодын зах зээлд эзлэх хувь нэмэгдсэн байна.	2	2022 оны 12 дугаар сарын байдлаар эмнэлгийн хэрэгслийн 83 хувийг импортлож, 17 хувийг дотоодод үйлдвэрлэсэн байна. ЭМЯ-наас 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр дотоодын үйлдвэрүүдтэй холбоотой тулгамдаж буй асуудлаар ЭЭХХЗГ, ЗӨСҮТ, НЭМҮТөвийн дарга, удирдлагуудтай уулзалт хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд: ЭЭХХЗГгазраас эмийн-10, БИБ-7, уламжлалт эмийн-5, биобэлдмэлийн-1, нийт 23 үйлдвэрт үнэлгээ хийсэн. Үйлдвэрүүдийн зүгээс түүхий эдийн үнийн өсөлт, тээвэрлэлтийн зардал өссөн зэргээс хамаарч санхүүжилт хүндрэлтэй байгаа тул татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх хүсэлт гаргасан. Дотоодын үйлдвэр	100.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийг эх орондоо үйлдвэрлэдэг болоход түүхий эдийг татвараас чөлөөлөх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх				ханган нийлүүлэх байгууллагыг дэмжих үүднээс "Эрүүл мэндийн технологи-2022" үзэсгэлэнг 2022 оны 10 дугаар сарын 07-09-ны өдөр зохион байгуулж, тоног төхөөрөмж ханган нийлүүлэгч 14, Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 41, БНСУ-аас 11 аж ахуйн нэгж оролцсон. Үүнээс эм, эмнэлгийн хэрэгслийн 5 үйлдвэр оролцож, өөрсдийн бүтээгдэхүүнээ танилцуулж, борлуулалт хийсэн байна.	
22		2.1.17. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг бий болгон, чадавхыг бэхжүүлэх Шалгуур үзүүлэлт: Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг бий болгон, чадавхыг бэхжүүлэх		Шинээр 3 бүсийн оношилгоо, эмчилгээний төвд төгсөлтийн дараах сургалт явуулдаг болсон байна.		Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрлийг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлын 5, 6, 7 дугаар тогтоолоор олгосон. 2022-2023 оны хичээлийн жилд Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтад Өвөрхангай 3, Өмнөговь 1, Ховд 2 резидент, нийт 6 эмч элсүүлэн сургаж байна. Өмнөх онд сургалт эрхлэх зөвшөөрөл авсан Орхон 3, Дорнод 3, нийт 6 эмчийг элсүүлэн сургаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтад дээрх 5 Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд нийт 12 резидент эмчийг сургаж байна.	100.0
23		2.1.18. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож,		Бүх өрх, сум, тосгоны-эрүүл мэндийн төвд нэвтрүүлж эхэлнэ.		Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн журмыг шинэчилж ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолоор баталж, 2022 оны 04 дүгээр сарын 01-нээс хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн ЭМДҮЗ-ийн 13 дугаар тогтоолоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үлгэрчилсэн гэрээ, гэрээний	100.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		<p>гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэх</p> <p>Шалгуур үзүүлэлт: Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэх</p>				<p>хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг батлуулж сар бүр 80 хувийн урьдчилгаа санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 20 хувийг хянаж олгохоор зохицуулсан. Ингэснээр иргэн анхан шатны тусламж, үйлчилгээг хаанаас авч байгааг цахимаар хянаж, тусламж, үйлчилгээ үзүүлж буй анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх боломж бүрдсэн. Хэрэгжилтийн явцад эрүүл мэндийн байгууллагуудын программ хангамж хугацаандаа ашиглалтад ороогүйтэй холбоотой ЭМДҮЗ-ийн 09, 14 дүгээр тогтоолыг гаргаж санхүүжилтийг олгож ажилласан.</p>	
24		<p>2.1.19. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх</p> <p>Шалгуур үзүүлэлт: “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх</p>		Арга хэмжээний хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна.		<p>Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 5 зорилт, 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны эхний 11 сарын байдлаар 35.8 хувьтай байна.</p>	70.0 (89.5)
25		<p>2.1.20. “Хавдрын эсрэг” арга хэмжээг эхлүүлж, хүн амын</p>		Хорт хавдрыг эрт-илрүүлэх үзлэгийн		<p>Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаалаар батлагдсан “Хавдрын эсрэг” арга хэмжээ төлөвлөгөөнд 6 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр</p>	70.0 (79.6)

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		<p>дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: “Хавдрын эсрэг” арга хэмжээг эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах</p>		хамралтын түвшин 30 хувьд хүрсэн байна.		<p>тусгагдсан бөгөөд 2022 онд 21 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт улсын хэмжээнд 765,264 хүн хамрагдсанаас 351,006 буюу 45.9 хувь нь эрэгтэйчүүд, 414,258 буюу 54.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Үзлэгт хамрагдсан 18-60 насны хүн амаас хавдрын 409 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 18-30 насны ангилалд 7 тохиолдол буюу 1.7%, 31-45 насны ангилалд 98 тохиолдол буюу 24.0%, 46-60 насны ангилалд 304 тохиолдол буюу 74.3%-ийг эзэлж байна. 31-45 насныхны дунд элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн 22.4%, хөхний өмөн 20.4%, ходоодны өмөн 19.4%-ийг тус тус эзэлж байна. 61-ээс дээш насны ангилалд хорт хавдрын 454 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн 40.5%, ходоодны өмөн 19.8%, улаан хоолойн өмөн 10.1%-ийг тус тус эзэлж байна. Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралт 23.9 хувьтай байна.</p>	
26		<p>2.1.21. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний делта вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний делта вирустэй иргэдийг</p>		Арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна.		<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/577 дугаар тушаалаар “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр баталсан байна. Арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилт, 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.</p> <p>Элэгний D вирусийн эсрэг Bulevirtide (Hepcludex) эмийг Хүний эмийн зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/347 дугаар тушаалаар 2 жилийн хугацаагаар өнчин эмийн жагсаалтад оруулсан. Гэвч D вирусийн эмийг манай улсад импортлон оруулж ирэхгүй байгаа тул иргэдийг эмийн эмчилгээнд хамруулах ажил удааширсан. Шалтгаан нь Bulevirtide эм нь анх лиценз эзэмшигч MYR GmbH компанийн нэр дээр Европын эмийн агентлагт нөхцөлт зөвшөөрөл авсан бөгөөд эзэмшигчийн лиценз нь АНУ-ын Гилеад</p>	0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		эмчилгээнд хамруулах				Сайенс компанид 2020 оны 12 дугаар сард шилжиж, улмаар АНУ-ын Хүнс эмийн агентлагт (FDA) Bulevirtide эмийг бүртгүүлэхээр хүлээгдэж байна. Эмийн эмчилгээний талаар Гилеад Сайенс компаниас 2022 оны 06 дугаар сарын 04-ны өдөр монголын эмч нарт сургалтыг зохион байгуулсан.	
27		2.1.22. “Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх Шалгуур үзүүлэлт: “Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх		Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.		Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/816 дугаар тушаалаар батлагдсан "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилт, 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны эхний 11 сарын байдлаар 50.3 хувьтай байна.	70.0 (71.8)
28		2.1.23. Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангах Шалгуур үзүүлэлт: Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник,		Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавх бэхэжсэн байна.		Алсын зайн болон яаралтай тусламжийн үйл ажиллагаанд ашиглах туулах чадвар өндөртэй түргэн тусламжийн автомашиныг 21 аймаг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв зэрэг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад нийт 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгоод байна. Мөн түргэн тусламжийн УАЗ-фургон автомашиныг 11 аймгийн 22 сумын эрүүл мэндийн төвд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгож ашиглалтад оруулаад байна. Япон Улсын Засгийн газраас Хөгжлийн төлөвлөлтийн техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-ийн коронавируст халдвар КОВИД-19-ыг эмчлэх, урьдчилан сэргийлэх, эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд 8 ширхэг иж бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн	100.0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		тоног төхөөрөмжөөр хангах				автомашиныг 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгчээ. ОХУ-ын Москва хотноо тус улсын Эрүүлийг хамгаалах яамны харьяа Хүүхдийн анагаах ухааны эрдэм шинжилгээний үндэсний төвд “Хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх зарчмууд” сэдэвт сургалтад Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Өргөө амаржих газраас нийт 15 эмч 2022 оны 07 дугаар сарын 11-22-ны өдрүүдэд оролцсон. БНХАУ-ын Хунань мужийн хүүхдийн эмнэлгээс зохион байгуулж, 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлсэн Яаралтай тусламжийн сувилахуйн 3 долоо хоногийн цахим сургалтад 21 аймаг, нийслэлийн яаралтай тусламжийн 25 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж байна.	
29		2.1.24. Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах Шалгуур үзүүлэлт: Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах		Эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог бий болгож, бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбоно.		ЭМДЕГ-ын Health.gov.mn цахим системд өргөтгөл хийж, эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн санхүүжилт олгох үйл ажиллагаа бүрэн цахимжсан.	100.0
30		2.1.25. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II-ыг байгуулах ажлыг эхлүүлэх Шалгуур үзүүлэлт: Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II-ыг		Цогцолбор салбар II-ын барилга баригдаж эхэлсэн байна.		Халдварт өвчин судлалын төвийн цогцолбор салбар байгуулах зураг төслийн ажлыг гүйцэтгэсэн. Төв аймгийн Сэргэлэн сумын 20 га газрыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд шилжүүлэн гэрчилгээг олгосон. 2023 оны төсвийн тухай хуулийн барилга байгууламжийн жагсаалтад санал хүргүүлсэн. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар-II барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй.	0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		байгуулах ажлыг эхлүүлэх					
31		2.1.26. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх Шалгуур үзүүлэлт: Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх		Хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.	-	Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор эрүүл мэндийн ажилчдын цалингийн доод жишгийг шинэчлэн тогтоож, эрүүл мэндийн байгууллагууд эмч, ажилчдын цалинг нэмэгдүүлсэн байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Хархорин сум нь эмч, ажилчдын үндсэн цалинг 10-25 хувиар нэмэгдүүлж, улирал бүр урамшуулал, Хавдар судлалын үндэсний төв эмч, ажилчдынхаа үндсэн цалинг 43 хүртэл хувиар нэмэгдүүлэхээс гадна 15 хүртэлх сая төгрөгийн урамшуулал, Гэмтэл, согог судлалын үндэсний төв эмч, эмнэлгийн ажилчиддаа 500.000 төгрөгийн урамшуулал олгож, сувилагч нарын үндсэн цалинг 10-25 хувиар нэмсэн, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв 2021 онд нийт ажилчдынхаа цалинг 30 хувь нэмэгдүүлсэн бол 2022 онд гүйцэтгэлтэй нь уялдуулан 20 хувь нэмэгдүүлсэн байна. Амгалан амаржих газар 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эмч эмнэлгийн ажилчдын цалингаа 10-20 хувиар нэмсэн байна. УНТЭ гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дүнд 2022 онд 33 эмч, ажилтандаа орон сууцны урьдчилгаа болох тус бүр 30 сая хүртэлх төгрөг олгосон, УГТЭ нийт ажилчидынхаа үндсэн цалинг 40 хувиар нэмэгдүүлжээ. Эмч, ажилчдынхаа үндсэн цалинг нэмэхийн зэрэгцээ орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн ЭМТ-ийн 17 ажилтанд орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд 30.0 сая төгрөг, 20 ажилтанд орон сууцны зээлийн хөнгөлөлтөд 20.0 сая төгрөг, 11 ажилтанд монгол гэр тус бүр олгосон байна.	70.0
32		2.1.27. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах		Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг даатгалын санхүүжилтийн 8	-	ЭМДҮЗ-ийн 2021 оны 10 дугаар тогтоолоор эрсдэлийн санг 40 тэрбум төгрөгөөр буюу 2022 оны даатгалын санхүүжилтийн 2.8 хувиар байгуулсан байна. Коронавируст халдварын үеийн эдийн засаг, санхүүгийн хүндрэл, инфляци, валютын ханшийн	30.0 (35.0)

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		Шалгуур үзүүлэлт: Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах		хувиар байгуулсан байна.		өсөлттэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх орлого буурч, төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд шаардагдах төсвийн эх үүсвэр дутагдсан тул эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Эрүүл мэндийн даатгалын 2022 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай” 13 дугаар тогтоолоор гаргажээ.	
33		2.1.28. Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ыг байгуулах ажлын зураг, төсвийг боловсруулах Шалгуур үзүүлэлт: Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ыг байгуулах ажлын зураг, төсвийг боловсруулах		Зураг, төсөв хийгдэж, барилгын ажлыг эхлүүлсэн байна.		Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Барилга, хот байгуулалтын сайдын багцад зураг төсөв боловсруулах төсвийг тусгасан бөгөөд Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын байгуулсан үнэлгээний хороо худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зураг төсвийн ажил 80 хувьтай үргэлжилж байна. Газрын асуудал шийдэгдэж, Баянзүрх дүүргийн Чулуутын аманд 10 га газарт барилга барихаар болсон. Хавдар судлалын үндэсний төвийн салбар-II барилгын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн төсөл болон гадаадын, зээл тусламжийн хөрөнгөөр шийдвэрлэх саналыг Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн боловч батлагдаагүй.	30.0
34		2.1.29. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох Шалгуур үзүүлэлт: Эрүүл мэндийн анхан шатны		3 аймгийн нийт 15-сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна.		Ус, ариун цэврийн байгууламжийн түргэвчилсэн үнэлгээний асуумжийг ЭМЯ, НЭМҮТ, МХЕГ хамтран 2022 онд боловсруулж, судалгаа авсан. Ариун цэврийн байгууламж, бохир ус зайлуулах систем, ус хангамж, гарын эрүүл ахуй, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн байдал зэрэг чиглэлээр асуумжийг 21 аймгийн нийт 358 сумын Эрүүл мэндийн төвөөс авч нэгтгэн улсын хэмжээний нөхцөл байдлын талаарх мэдээллийг боловсруулсан. Судалгаанд хамрагдсан сумын ЭМТ-ийн 76.5% нь нүхэн жорлон тогтмол ашигладаг, 13.1% нь хааяа ашигладаг, 2.0% огт ашигладаггүй бол 8.4% нь гадна нүхэн жорлонгүй байна.	0

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох				Нүхэн жорлон ашигладаг байдлыг бүсээр харахад баруун бүсийн сумын ЭМТ хамгийн их буюу 89.2%, зүүн бүс 78.6%, хангайн бүс 78.1%, төвийн бүс 60%-д нүхэн жорлон тогтмол ашигладаг байна. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд 24,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй санхүүжих дүн 1,8 тэрбум төгрөгөөр батлагдсан. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжийн зураг төсөл хийгдэж байна.	
35		2.1.30. “КОВИД-19” халдварт вирусийн эмчилгээнд нэн шаардлагатай уушги орлуулагч ЭКМО аппаратын тоог нэмэгдүүлэх Шалгуур үзүүлэлт: “КОВИД-19” халдварт вирусийн эмчилгээнд нэн шаардлагатай уушги орлуулагч ЭКМО аппаратын тоог нэмэгдүүлэх		Уушги орлуулагч-ЭКМО аппарат худалдан авч эмчилгээнд ашигласнаар тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.		Уушги орлуулагч ЭКМО аппаратыг 2022 оны эхний 10 сарын байдлаар УНТЭ 22, УГТЭ 2, ХӨСҮТ 1, ЦТЭ 5, нийт 30 хүнд эмчилгээ хийхэд ашиглаж, 61.5 хувийн үр дүнтэй байсан.	90.0
36		2.1.31. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийн засвар шинэчлэлтийн ажлыг хийх Шалгуур үзүүлэлт: Аймаг, сумын эрүүл		Тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.		“Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд 387,573.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ тусгаснаас 2022 онд 72,898.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталжээ. Он дамжин хэрэгжиж байгаа 2022 онд дуусгавар болох ёстой 33 барилгаас 19 барилгын ажил бүрэн дуусгавар болж (100%), улсын комисс хүлээн авсан. Улсын комисс ажиллахаар бэлтгэл хангаж байгаа 2 барилга 90 хувийн гүйцэтгэлтэй байна. 11 барилгын ажлын явц 62.8%-ийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь үнийн өсөлт болон төсөвт	70.0 (84.3)

Д/д	Зорилго	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээний хувь
		мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийн засвар шинэчлэлтийн ажлыг хийх				өртгийн нэмэгдлээс шалтгаалан 2022 онд ашиглалтад орохгүйгээр 2023 онд шилжсэн болно. Нэг барилгын гүйцэтгэгч шалгараагүй, учир нь төсөвт өртөгт тохирсон компани тендерт оролцоогүй байна. 2022 онд шинээр эхлэх 36 барилгаас 31 барилгын ажлын явц 26.2% байна. 5 барилга худалдан авах ажиллагааны шатанд байна. Барилгын ажил технологийн шаардлагаас хамааран зогссон байна.	
37	2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	2.1.32. Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барих Шалгуур үзүүлэлт: Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барих		Барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 40 хувьд хүргэсэн байна.		Энэхүү арга хэмжээг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд хэрэгжүүлнэ. Уг төсөл нь 3 үе шаттай бөгөөд I үе шатын хүрээнд “Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл”-ийн зургийн зөвлөх компани “Татах хүч” ХХК шалгарч 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Ажлын явц 40 хувьтай байна. Түүнчлэн 2022 онд Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийн зураг төсөв хийхээр “Татах хүч” ХХК-тай 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын эскиз зургийг дуусган, ЭМЯ-ны ТАХ-аар 10 дугаар сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, аймгийн ерөнхий архитектораар батлуулахаар хүргүүлсэн. Барилга архитектурын зургийг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор эцэслэн, ОБЕГ, МХЕГ, БХТ-т хүргүүлэн магадлалд оруулахаар ажиллаж байна.	0
ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ						65.1	

Эрүүл мэндийн яам
2022 оны 12 дугаар сар